



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 05 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар ТУЗ2024-03/03

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, тус компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7-р дах хэсэгт гишүүдийн дийлэнх олонхын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Цагаачийн Баатарсайханыг сонгосныг баталсугай.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан компанийн дүрэм болон ТУЗ-ийн хурлаар баталсан дүрэм, журмийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар ТУЗ2024-03/04

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.1 дэх хэсэг, тус компанийн дүрмийн дугаар зүйлийн 8.9.11-р зүйл, Компанийн засаглалын кодексыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Дотоод аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороотой байхыг тогтоосугай.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан хороодын дарга, гишүүдийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар баталсугай.

2.1 Эрсдэл, аудитын хорооны даргаар: Ц.Оюунцэцэг

Гишүүдэд: Н.Мөнхбат
Д.Уянга

2.2 Нэр дэвшүүлэх хорооны даргаар: Д.Байгальмаа

Гишүүдэд: Э.Пүрэвлхам
Ц.Отгонсүрэн

2.3 Цалин, урамшууллын хорооны даргаар: Д.Болормаа

Гишүүдэд: Ц.Оюунцэцэг
Н.Мөнхбат

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь харьяалсан хороодын үйл ажиллагаанд зохих журмын дагуу оролцож компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
Сарын 08-ны өдөр

Дугаар ТУЗ2024-03/05

Улаанбаатар
хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.10, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 28-р тогтоол, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ НЬ:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн үйл ажиллагаа эрхэлж байсан нийт хугацаанд хуримтлагдсан ашгийн хэмжээ 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,978,330,266 төгрөгт хүрсэн болохыг дурдсугай.

2. Нийт хуримтлагдсан ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 30,600 /гучин мянга зургаан зуун/ төгрөгөөр тооцож нийт 2,000,077,200 /хоёр тэрбум далан долоо мянга хоёр зуун/ төгрөгийг хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг болгон мөнгөн хэлбэрээр хуваарилахыг зөвшөөрсүгэй.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоосугай.

4. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу албан татварыг суутган тооцож “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигч нарт 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор тараасугай.

5. Энэхүү тогтоолд заасан ногдол ашгийг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид арилжааны банк дахь дансанд шилжүүлж авахаар бичгээр хүсэлт гаргаж ногдол ашгийг авах боломжтойг дурдсугай.

6. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Ц.Отгонбаяр), Ахлах нягтлан бодогч (С.Шижиртуяа) нарт үүрэг болгосугай.

7. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ногдол ашиг хуваарилах болсон тухай шийдвэр, шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн дараагийн зарлагдах хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Отгонбаяр), Ахлах нягтлан бодогч (С.Шижиртуяа) нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН